



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/529

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Ардын намын (8488908)-ын эзэмшлийн Э-1723000214 нэгж талбарын дугаартай 267м² газрыг аймгийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/217 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсэгт Монгол Ардын намын (8488908)-ын эзэмшлийн Э-1723000214 нэгж талбарын дугаартай газар эзэмшүүлснийг 125м² газрыг хэвээр үлдээж 142м² газрыг нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.


2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/217 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсэг болон газар эзэмших эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн санд өөрчлөлт оруулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ